

ОХУ-ын Монгол дахь ашиг сонирхол ба хөрөнгө оруулалт

Х.Мандухай*

1990 оноос өмнөх манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны явцад байгуулагдсан “Улаанбаатар төмөр зам” ХНН (1949), “Монголросцветмет”, “Эрдэнэт” зэрэг хамтарсан үйлдвэрүүд Монгол орны хөгжилд нэн чухал үүрэг гүйцэтгэж ирсэн түүхтэй. Өдгөө ч гэсэн манай эдийн засгийн хөгжлийн нэг гол ноён хүчин зүйл нь болсоор байна. 1990-ээд оны дунд үеэс хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг зах зээлийн шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх, хамтын ажиллагааны шинэ механизм бий болгосноор хоёр талын ашиг сонирхолын дагуу ОХУ-ын нийцэж хөрөнгө оруулалтын түвшинг дээшлүүлэх, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилт дэвшигдэж буйг харуулахыг хичээв.

Prior to 1990, “Ulaanbaatar Railway” JSC (1949), “Mongolrosvetmet”, “Erdenet” joint ventures, which were established during the period of cooperation between two our countries, have a rich history for a significant role in the development of Mongolia. Even though, they play an important factor of the Mongolian economy, today. I tried to indicate how should develop the efficient economic and commercial relations of two countries and create a new mechanism for cooperation as well as to increase an investment appropriate for interest of two parties and its outcome.

Түлхүүр үгс: Монгол Улс, ОХУ, худалдаа-эдийн засаг, хөрөнгө оруулалт, ашиг сонирхол, хамтарсан үйлдвэр, үр өгөөж, нөлөөлөл.

* Х.Мандухай ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан.

* * *



Алив улс төрийн сонирхлыг сэдэгч өдөөгч нь бодит сонирхол буюу эдийн засгийн сонирхол байдаг. Тиймд эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа нь тухайн улсын геополитикийн нэгэн гол чухал хүчин зүйл болдог. Энэ үүднээс Монгол Улс, Оросын Холбооны Улс (ОХУ)-ын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа буй болон тогтож, хөгжиж ирсэн түүхтэй. Үүний нэг тод жишээ бол социализмын үед үүсэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байгаа “Улаанбаатар төмөр зам (УБТЗ)” ХНН, “Монголросцветмет” нэгдэл, “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр” юм. Монгол, Оросын хамтын энэ үйлдвэрийн газрууд олон жилийн турш Монголын эдийн засгийн өсөлт хөгжил тод онцгой чухал үүрэг гүйцэтгэж ирсэн онцлогтой.

Зах зээлийн ороо бусгаа, шилжилтийн үеийн элдэв бэрхшээл, хүндрэлүүдийг амжилттай даван туулаад, өнөөдөр ч үйл ажиллагаагаа хэвийн явуулж, Монгол Улсын төсвийг бүрдүүлэх, нийгэмд тодорхой хэмжээний тогтворжилтыг бий болгох, хүн ардын амьжиргааг дээшлүүлэх зэрэг үйлсэд үлэмж чухал хувь нэмрээ оруулсаар байна.

Тухайлан “Эрдэнэт” үйлдвэрийн тухайд гэвэл ашиглалтанд орсон үеэс 2 тэрбум ам.долларын өртөг бүхий 250 сая м³ уулын масс, 390 сая тн хүдэр боловсруулан 2 сая тн илүү зэс, 20 мянга илүү тн молибдены баяжмалыг экспортод гаргаж эхлэжээ.¹ 2012 он хүртэл хөгжүүлэх үндсэн концепцид жилийн дундаж олборлолтыг 30 сая тн хүдэрт хүргэх төлөвлөгөө тавьж, амжилттай биелүүлсэн байна. Уг үйлдвэр нь одоо нийт бүтээгдэхүүнийхээ 70%-ийг Швейцарын 3 компанид, 13.5% Өмнөд Солонгост, 11.5%-ийг Японд, 5.0%-ийг АНУ-д тус тус нийлүүлдэг бол молибдений хүдрийн 38.2%-ийг АНУ-д, 34.0%-ийг Их Британид, 17.7%-ийг БНХАУ-д, 10,1%-ийг ОХУ-д тус тус гаргадаг байна.² 1991 онд хамтарсан үйлдвэрийг Оросын талын 49%, Монголын талын 51%-ийн хувьцаа бүхий компани болгосон. Мөн үйлдвэрийг

¹ Д.Жамбалдорж, Р.Ганзориг Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны он жилүүд. УБ.2007. 44-45 дахь тал

² “Зууны мэдээ”, 2011.11.27. №299

анхлан барихад зориулж монголын талын авсан зээлийг 2003 онд бүрэн төлж дууссан хэмээн талууд үзсэн.

Монгол, Оросын хамтын ажиллагаанд чухал үүрэг бүхий субъект бол “Монросцветмет”. Тус нэгдэл нь анх “Монсовцветмет” нэртэйгээр 1973 оны 02 сарын 24-ны өдрийн Засгийн газар хоорондын комиссын шийдвэрээр байгуулагдсан аж субъект юм. Энэхүү нэгдлийн бүрэлдэхүүнд 5 хайлуур жоншны, 2 нүүрсний, 2 алтны олдворлох үйлдвэрүүдээс гадна барилгын болон туслах аж ахуйнууд ордог. Эдгээр үйлдвэрүүд нь 7 аймгийн нутаг дэвсгэр дээр 5000 гаруй ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа³ нь аймаг орон нутгийн төсөв, санхүүг бүрдүүлж өгөхөд тус дөхөм үзүүлсээр байгаа аж.

Монголын төмөр зам “МТЗ” хэмээн монголчуудын нэрлэдэг, харин оросууд болохоор “УБЖД” гэж нэрлэж ирсэн энэхүү хамтарсан үйлдвэрийн газар нь Монголын нийт ачаа эргэлтийн 80%, хүн тээврийн 50% хувийг дангаараа эзэлдэг.⁴ Сүүлийн жилүүдэд “Эрдэнэт”, “УБТЗ” хамтарсан үйлдвэрийн газрууд манай шилдэг 10 аж ахуйн нэгжийн эхний 1-3 байрт байнга шалгарсаар иржээ.

Дээрхи гурван хамтарсан үйлдвэрүүд нь ОХУ-ын хөрөнгө оруулалтад хамгийн чухал байр суурь эзэлдэг. Харин одоо техник, технологийн шинэчлэлийг хийж түргэтгэх, эрхзүйн болон өмчийн хэлбэрийг оновчтой тодорхойлох асуудлаар хоёр тал нэгдсэн тохиролцоонд хүрэхээр тууштай ажиллаж байгаа аж. Мөн харилцан хөрөнгө оруулалтыг урамшуулах, зорилт тавьж, үр ашгийг дээшлүүлэх. Гэвч бодит ажил хэрэг болгох талаар хоёр тал идэвхийлэн ажиллаж байна.

Шилжилтийн хүнд бэрхшээлтэй он жилүүдэд ОХУ-ын олон тооны хамтарсан аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн салбарууд шинээр бүртгэгдэн ажиллаж, шууд хөрөнгө оруулалт хийж байв.

Тухайлан Оросын тал Монголын уул уурхайн олборлох салбарт

³ Д.Жамбалдорж, Р.Ганзориг. Дурдсан зохиол. УБ. 2007, 45 дахь тал

⁴ Мөн тэнд

ОЛОН УЛС СУДЛАЛ

гэхэд л Оросын “Зарубежцветмет” компаниас 2,1 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж “Шижир Алт” ХХК нь 1995 онд байгуулагдсан алт олборлох хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр ажиллаж байна. ОХУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Чингис хаан” банк нь зөвхөн банк санхүүгийн салбарт амжилттай ажиллаж байгаа төдийгүй Монголын бизнесийн салбарт үлэмж хөрөнгө оруулалт хийж байна.⁵ Цаашдаа Оросоос Монголд оруулах шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, чанарыг анхаарах ёстой гэдгийг хоёр талын дээд, дунд түвшинд болдог уулзалт хэлэлцээрийн үеэр байнга яригддаг болжээ.

1990-ээд оны эхнээс Монгол-Оросын хоорондын худалдаа эдийн засгийн харилцаа эрс хорогдсон. Тухайлвал 1990 онд Монголоос Орос улсад гаргасан экспортын хэмжээ 517,5 сая ам.доллар байсан бол 1995 онд 68,5 сая ам.доллар болтол буурч, Монголд Оросоос оруулсан импорт мөн хугацаанд 951,6 сая ам.доллараас 208 сая ам.доллар хүртэл доошилсон байв.⁶

Үүнийг дагалдан ОХУ-аас Монголд оруулах хөрөнгө оруулалт эрс багассан байна. Энэ нь юуны өмнө хоёр орны аль алинд нийгэм-улс төрийн хуучин тогтолцоо өөрчлөгдөж, шилжилт шинэчлэлтийн үйл явц өрнөсөнтэй, өөрөөр хэлвэл манай хоёр улсын эдийн засгийн хэвшлийг өөрчлөж халах, хоорондын их хамаарлыг багасгахтай холбоотой гэж үздэг. Харин 1990-ээд оны хоёрдугаар хагасаас эхлэн манай хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаа аажим аажмаар сэргэж, өөдөлж дээшлэх байдал илтэд гарах болсон байна. Үүнийг манайхны үнэлж дүгнэснээр биш Оросын судлаач шинжээчдийн бичсэнийг энд дурьдая.

Тэдний бичсэнээр, Монголын засгийн газраас 1990-ээд оны эхэн үеэс явуулсан нээлттэй эдийн засаг, худалдааны болон хөрөнгө оруулалтын илүү таатай чиг бодлого нь түүнийг хуучин Зөвлөлтийн “хавхнаас салгах ганц зөв зам байсан” хэмээн тэмдэглэжээ.⁷ Монгол

⁵ Монгол-Оросын харилцаа: Бүсийн хамтын ажиллагаа. УБ.2005 он. 105 дахь тал

⁶ Б.Лхамсүрэн. Монгол ба ОХУ-ын 1990-ээд оны харилцааг үечлэн авч үзэх нь- “Олон улс судлал”, 2001. №1.19 дэх тал

⁷“Өнөөдөр”, 1999.12.11

Улсад 1990-2009 оны хооронд ОХУ-аас нийт 115 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.⁸

Дээрх хугацаанд ОХУ-ын шууд хөрөнгө оруулалттай нийт 752 компани бүртгэгдэж үйл ажиллагаагаа явуулж байв. Тэдгээрийн хувь нь худалдаа, үйлчилгээний, бусад нь барилга, геологи хайгуулын салбарт тус тус хамрагджээ.

Барилга, уул уурхай, банкны салбарт хөрөнгө оруулсан компаниудаас бусад салбарт хөрөнгө оруулсан Оросын компаниуд дорвитой үйл ажиллагаа явуулж чадалгүй, байгуулагдсанаасаа хойш 3-4 жил болоод л татан буугдаж байжээ.

Үүний гол шалтгаан нь хөрөнгө оруулалтын орчин, зах зээлийн судалгааг дутуу дулимаг хийсэн, хууль эрхзүйн мэдлэг дутмаг, хамтран ажиллагчаа оновчтой сонгож чадаагүй, хөрөнгө мөнгөний чадавхи сул зэрэг болно. Үүнээс үүдэн урьдах онуудад байгуулагдан ажиллаж байсан компаниудын тоо үлэмж цөөрсөн талтай. Үнэндээ гадаадын бусад орныг бодвол ОХУ-ын хөрөнгө оруулагчдыг манай улсад татах асар их боломж байдаг билээ.

Тухайлбал, олон мянган км газраар шууд хил залгадаг, хөрш орнууд хийгээд, олон жилийн хамтын ажиллагааны уламжлалтай, манай улстай агаар, төмөр болон авто замаар шууд холбогдсон, хэл соёлын саад тотгор бага зэргийг дурьдаж болно.

Монгол, Оросын ажил хэрэгч хүмүүсийн уулзалтуудын үеэр хоёр талаасаа хамтран ажиллах сонирхол, эрмэлзэл их байгаа нь ажиглагддаг ба ялангуяа Оросын жижиг дунд үйлдвэрлэгчид манай татварын систем Оросынхоос илүү таатай, уян хатан гэдгийг тэмдэглэдэг юм. Иймд цаашид ОХУ-тай хөрөнгө оруулалтын талаар хамтран ажиллахдаа дараах чиглэлийг баримтлах бодлого барьж буй аж. Үүнд:

- Хоёр талын худалдан авах чадварыг харгалзан голлон жижиг дунд үйлдвэрлэгчдийг түлхүү дэмжих;

⁸ <http://economics.gogo.mn/news/63636>

ОЛОН УЛС СУДЛАЛ

- Оросын хөрөнгө оруулагчдыг дэд бүтэц, уул уурхай, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, хөнгөн, хүнсний үйлдвэр, аялал жуулчлал, дээд боловсрол, шинжлэх ухааны салбарт түлхүү оруулах;
- Хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх болон хөрөнгө оруулах боломжийг нээх талаар олон нийтэд өргөн сурталчлан таниулах зорилгоор уулзалт, үзэсгэлэн, семинар, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулах, тэдгээрт хил орчмын бүс нутгийн төлөөллийг өргөн хамруулах;
- Уул уурхайн салбарт: тухайлан ураны салбарт идэвхитэй хамтран ажиллах;
- Монгол Улсаас уул уурхайн бүтээгдэхүүнийг Оросын Холбооны Улсын Алс дорнодын боомтуудад дамжин хүргэж тээвэрлэх, түүний дотор төмөр замын урт хугацааны хөнгөлөлттэй тариф тогтоохтой холбогдсон асуудлыг тохиролцож харилцан ашигтай шийдэлд хүрэх явдал шаардлагатай байгаа.
- Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн салбарт хамтран ажиллах зорилгоор “Уран олборлох болон атомын энергийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Мэргэжилтэн бэлтгэх талаар харилцан ойлголцлын Санамж бичиг”, “Дорнод Уран” хамтарсан ХХК байгуулах хэлэлцээр зэрэг баримт бичиг байгуулагсанаар цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглахад ОХУ-тай хамтран ажиллах алхам нээгдэж байгааг ажил хэрэг болгож, үр дүнд хүрэх ёстой байгаа зэрэг болно.⁹

Сүүлийн жилүүдэд ОХУ-ын “Базовый элемент”, “Русал”, “Реново”, “Севесталь”, “Полиметалл”, “Газпромбанк” зэрэг санхүү, үйлдвэрлэлийн бүлэглэлүүд, Таван толгой зэрэг нүүрсний ордуудад хөрөнгө оруулалт хийх, байгалийн хийн дэд бүтцийг байгуулах сонирхолтойгоо илэрхийлж, төлөөлөгчдийн газруудаа Улаанбаатарт хотод байгуулсан байна.¹⁰

⁹ Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн Газар хоорондын комиссын үйл ажиллагааны хөтөлбөр. УБ 2010.

¹⁰ “Зууны мэдээ”, 2006.01.20

Монголын уул уурхайн орд газруудад идэвхитэй оролцох, тухайлан уран олборлох гэсэн ОХУ-ын сонирхол улам нэмэгдэж байна. Энэ явдлыг дараах байдлаар тайлбарлаж болох юм. ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын шинэ стратегид эрчим хүчний эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн 2020 он хүртэлх их гүрнүүдийн харилцааг тодорхойлно гэж заасны дагуу Монгол Улс ч гэсэн нүүрс, ураны илэрсэн нөөцөөрөө тийм өрсөлдөөний нэгэн талбар болно гэж тооцоолоод Монголтой харилцаагаа идэвхжүүлэх боллоо гэж үзэж болно. Гэвч, хэрэг дээрээ Монголын ураны орд газрыг ашиглах лиценз Франц, Канад, Хятад гэх зэрэг орнуудын мэдэлд байгаад Оросууд ихээхэн эмзэглэж байгаа тал бий юм. Монголын Засгийн газартай хамтран байдлыг өөрт ашигтай байдлаар эргүүлж, энэхүү төсөлд давуу эрхтэй оролцохыг Оросууд чухалчилж сонирхож байна.

ОХУ өнөөдрийн байдлаар уран олборлолтоороо дэлхийд дөрөвдүгээрт яваа бөгөөд жилд 3400 тонн уран олборлодог боловч цөмийн эрчим хүчний жилийн хэрэгцээ нь ойролцоогоор 5000 тонн орчим байна. Энэхүү ураны хомсдолтой байдлаас гарахын тулд, ОХУ Монголын ураны ордуудад байр сууриа бэхжүүлэхийг эрмэлзэж, Оросын талаас “Атомредметзолото”, Монголын талаас “Монатом” гэсэн компаниуд 2008 оны 6 дугаар сард “Дорнод уран” хамтарсан үйлдвэр барих хэлэлцээрийг ийнхүү байгуулжээ.

Дэлхийд нөөцөөрөө дээгүүрт орж байгаа Таван толгойн нүүрсний олборлолтод ОХУ одоогоор тодорхой оролцож чадаагүй байгаа нь эдийн засгийн бодлогынхоо алдаа гэж үзэж, Монголын нүүрсний тээвэрлэлтэд төмөр замынхаа давуу талыг ашиглан оролцох нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Энэ ч үүднээс тэд төмөр зам бол геополитикийн гол хэрэгсэл гэж үздэг бодлогынхоо хүрээнд тус салбарт хамтын ажиллагааг эрс идэвхжүүлэх хандлага ажиглагдаж байна. ОХУ-ын Ерөнхий сайдын 2012 оны тавдугаар сарын 13-нд хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын ЗТБХБ-ын яам, ОХУ-ын Тээврийн яамны хооронд харилцан ойлголцох тухай санамж бичиг, “РЖД”, “Эрдэнэс МГЛ”, “УБТЗ”-ын хувь нийлүүлсэн хамтарсан компани байгуулах тухай гэрээнд гарын үсэг зурсан. Мөн оны 10 дугаар сард “Оросын төмөр зам” ХНН-ийн ерөнхийлөгч В.И.Якунин

болон ЗТБХБ-ын сайд Х.Баттулга нар Зүүнбаянгаас Даланзадгад /Таван толгой/ руу тавих төмөр замын төслийн хэрэгжилтийг эхлүүлэх тухай санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд үүний хүрээнд ОХУ-ын тал 256 сая долларын хөрөнгө оруулалтыг хийхээ мэдэгдэв.¹¹ Энэ нь зогсонго байдалд орсон нь Монголын Холбогдох байгууллага, эрхтэн дархтануудтай холбоотой юм.

Дээрх байдлаас үзэхэд, оросууд Монголын стратегийн гол орд газрын бүс нутаг Өмнөговийг Сайншандтай өргөн төмөр замаар холбох, цаашдаа Сайншандыг Чойбалсан-Чита-ийн шугамтай холбохыг зорьж байна. Энэ ч зорилгоор Монголд хөрөнгө оруулж, төмөр замын хамтарсан шинэ компани байгууллаа.

2012 оны байдлаар манай улсад ОХУ-ын хөрөнгө оруулалттай 300 орчим аж ахуй нэгж үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээгээр ОХУ зөвхөн эхний 10 орны тоонд ордог. Энэ нь үнэхээр хангалтгүй байгаа юм. Учир нь өнөөдөр ОХУ нь дэлхийд аравт орох том эдийн засагтай, 500 гаруй тэрбум ам.долларын гадаад валютын нөөцтэй, гадаадын олон оронд үлэмж хэмжээний хөрөнгө оруулах чадвартай болж чадсан. Гэтэл хамгийн ойрын хөрш-манай улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын дөнгөж хоёр хувийг л ОХУ эзэлж байна.

ОХУ-ын зүгээс манайд үзүүлж буй өнөөгийн нөлөөний талаар зарим нэгэн жишээ хэлье

Бензин шатахуун. Манай улсын хувьд шатахууны хэрэгцээнийхээ 90 гаруй хувийг тус улсаас импортлон авдаг. Ийм ч учраас шатахууны үнэ болон нийлүүлэлтийг тойрсон асуудал гарах нь элбэг. Манай улс газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах талаар олон жил ярьж байгаа ч түүхий нефтийн хангамжийн асуудал тодорхойгүй байдгаас өнөөг хүртэл шийдвэрлэж чадаагүй байгаа. ОХУ-ын хувьд Монголд нефть боловсруулах үйлдвэр байгуулах бол 60-аас дээш хувийг эзэмшиж, манай дотоодын бензин шатахууны жижиглэн худалдаанд оролцох зэрэг нөхцөл тавьдаг ч энэ нь манай бодлоготой нийцдэггүй.

¹¹“Өнөөдөр” (сонин). 2000.10.19

Иймд, цаашдаа өөрийн улсад олборлож буй газрын түүхий тосоо ашиглан багавтар шиг хүчин чадалтай үйлдвэрүүдийг барих бодлогоо хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Үүнээс гадна өөр улс орноос бензин шатахуун авах замаар хэд хэдэн эх үүсвэртэй болох яриа хэлэлцээр нэлээд үр дүнтэй явагдаж хандлагатай байгаа тал мэдрэгдэж байна.

Цахилгаан эрчим хүч. Дотоодын эх үүсвэр хүрэлцэхгүйн улмаас нутгийн баруун болон хойд талаараа ОХУ-аас багагүй хэмжээний цахилгаан импортлон авдаг. Харин импортын эрчим хүчний асуудал нь импортын газрын тосны асуудалтай харьцуулахад цахилгааны үнийг цаг тухайд нь төлсөн нөхцөлд асуудал үүсгэх нь бага байгаа. Цаашдаа нүүрс болон томоохон гол мөрнөө ашиглан том хүчин чадал бүхий цахилгаан станцууд баригдах тохиолдолд асуудал шийдэгдэх боломжтой юм.

“Эрдэнэт” ХХК /зэс молибдин/. Эрдэнэтийн Уулын Баяжуулах үйлдвэр (УБҮ) 51:49 хувийн хоёр талын өмчлөлтэй байдаг. Тус үйлдвэртэй холбоотой хоёр талын хооронд асуудал бараг байхгүй гэж хэлж болно. Харин манай талаас зэс хайлуулах үйлдвэр барих асуудлыг олон жил ярьж байгаа боловч хайлах технологи зэрэг асуудлаас болоод өнөөг хүртэл үр дүнд хүрээгүй байна.

“Монголросцветмет” ХХК /жонш/. Тус үйлдвэрийн нэр дээр байдаг зарим ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийг эс тооцвол асуудал байхгүй.

“УБТЗ” ХХН. Тус байгууллагын хувьд үйл ажиллагааг нь Монгол Улсын хууль, дүрэм, журамд нийцүүлэх, татвар төлдөг болгуулах, суурь бүтцийг салгах, улмаар өөрийн мэдэлд авах, техникийн шинэчлэлийг шийдвэрлэх гэх мэт олон асуудал байгаа боловч Монгол-Оросын 50:50 хувийн өмчлөлтэй тул асуудлыг шийдэхэд нэлээд төвөгтэй байдаг тал бий юм. Тэгэвч Монгол-Оросын төмөр замын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах үүднээс “УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэгийг байгуулах тухай Монгол Улс, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх талаар хоёр тал идэвхийлэн ажиллаж байна.¹²

¹² “ОХУ, БНХАУ 2011 онд” хэмээх судалгааны эмхэтгэлийн “Монгол, Оросын харилцаа” харилцааны хэсэг. УБ. 2012 он.

ОЛОН УЛС СУДЛАЛ

Эцэст нь дүгнэлт байдлаар хэлэхэд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд манай улсад орж ирсэн Өмнөд их хөрш-Хятадын хөрөнгө оруулалт даруй 13 дахин их байна. Тийнхүү Хятадын нөлөө өдрөөр биш цагаар нэмэгдэж байхад Орос, Монголын худалдаа, эдийн засгийн харилцаа өсөж дээшлэх нь маш удаан байна. Жишээлвэл, 2012 онд манай нийт экспортын 93,6 хувь нь урд хөрш рүү, ердөө 2,7 хувь нь хойд хөрш рүү гарсан байна.¹³ Ийм тэнцвэргүй байхад “хоёр их хөрштэйгээ тэнцвэртэй харилцаа” хөгжиж байна, хөгжүүлж байна гэж хэлэхэд хэцүүхэн байна. Энэ талаар хоёр тал харилцан ойлголцож хамтран ажиллах чигт хэлэлцэн тохиролцоод байгаа нь сайн талтай юм.

Ном зүй

1. Д.Жамбалдорж, Р.Ганзориг Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны он жилүүд. УБ.2007. 44-45 дахь тал
2. “Зууны мэдээ”, 2011.11.27. №299
3. Д.Жамбалдорж, Р.Ганзориг. Дурдсан зохиол. УБ. 2007, 45 дахь тал
4. Мөн тэнд
5. Монгол-Оросын харилцаа: Бүсийн хамтын ажиллагаа. УБ.2005 он. 105 дахь тал
6. Б.Лхамсүрэн. Монгол ба ОХУ-ын 1990-ээд оны харилцааг үечлэн авч үзэх нь- “Олон улс судлал”, 2001. №1.19 дэх тал
7. “Өнөөдөр”, 1999.12.11
8. <http://economics.gogo.mn/news/63636>
9. Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн Газар хоорондын комиссын үйл ажиллагааны хөтөлбөр. УБ 2010.
10. “Зууны мэдээ”, 2006.01.20
11. “Өнөөдөр” (сонин). 2000.10.19
12. “ОХУ, БНХАУ 2011 онд” хэмээх судалгааны эмхэтгэлийн “Монгол, Оросын харилцаа” харилцааны хэсэг. УБ. 2012 он.
13. “Өдрийн сонин”, 2013он. №21

¹³“Өдрийн сонин”, 2013он. №21